



АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 1170

Улаанбаатар хот

Г Удирдамжийг шинэчлэн батлах тухай

Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь хэсэг, Иргэний хуулийн 197 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын дүрмийн 6.12 дахь заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/222 тоот тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг дуудлага худалдаагаар зохион байгуулах удирдамж”-ийг нэгдүгээр хавсралтаар, Дуудлага худалдаанд оруулах тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг энэхүү удирдамж болон бусад холбогдох хууль, журмын хүрээнд нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтэс /Н.Бямбадорж/, Санхүү эдийн засгийн хэлтэс /Р.Баасандорж/, Мэдээллийн технологийн хэлтэс /И.Нэргүй/-т тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Х.Баярхүү/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус үйлдвэрийн газрын захирлын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/287 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.



"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГН
захирлын 2021 оны 09 сарын 07-дэдрийн
тоот тушаалын хавсралт 1

А/10

УХЛ0190 5324165

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААРЫН ДУУДЛАГА ХУДАЛДААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү удирдамжийн зорилго нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны сарын 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/222 тоот тушаалын хавсралтаар баталсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын хурээнд Улаанбаатар хотын сери бүхий 387 дугаар, орон нутгийн 18 дугаарын үнэ хаялцуулах үйл ажиллагааг зохион байгуулахад оршиж.

1.2 Дуудлага худалдааг зохион байгуулахдаа "Автотээврийн тухай хууль", "Иргэний хууль", "Цахим гарын үсгийн тухай хууль", "Хувь хүний нууцын тухай хууль", "Байгууллагын нууцын тухай хууль", "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам", "Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам", "Төрийн байгууллагын цахим хуудаст тавих шаардлага MNS 6285:2016 стандарт" болон бусад холбогдох хууль тогтсонж, эсэхж, удирдамжийг мөрдлөг болгоно.

Хоёр. Дуудлага худалдааг зохион байгуулах

2.1 Улсын бүртгэлийн дугаарын үнэ хаялцуулах үйл ажиллагааг тус үйлдвэрийн Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтэс, Санхүү эдийн засгийн хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс хамtran энэхүү удирдамжийн дагуу цахим хэлбэрээр зохион байгуулна.

2.2 Мэдээллийн технологийн хэлтэс нь дуудлага худалдааны программын хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн аюулгүй байдал, хөгжүүлэлтийг бүрэн хангаж ажиллана.

2.3 Санхүү эдийн засгийн хэлтэс нь дуудлага худалдааны дэнчинг хүлээн авах дуудлага худалдаанд оролцогчид буцаан олгох болон дуудлага худалдаагаар олгосон улсын бүртгэлийн дугаарын үнийг дансанд төвлөрүүлэн, холбогдох зардлыг суутган тооцож тусгай санд шилжүүлэх зэрэг санхүүгийн үйл ажиллагааг хариуцан ажиллана.

2.4 Бүртгэлийн хэлтэс нь худалдан борлуулах жагсаалтад орсон улсын бүртгэлийн дугаарыг эрэмбэлэн цахим системд тухай бүр оруулна.

2.5 Бүртгэлийн хэлтэс нь дуудлага худалдааны зарыг 30 хоногийн өмнө олон нийтийн хэвлэлт мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

2.6 Дуудлага худалдаанд оролцогчid үнийн саналаа ээлж дараалан өсгөх бөгөөд дуудлага худалдааны ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон оролцогч этгээд байна.

2.7 Дуудлага худалдаанд оролцогч бүртгүүлээгүй, нэг этгээд оролцсон, эсхүл оролцогчдоос зөвхөн нэг нь үнийн санал өгсөн бол тухайн дуудлага худалдааг хүчингүйд тооцено.

2.8 Бүртгүүлсэн этгээд дуудлага худалдаанд ороогүй бол түүнийг дуудлага худалдаанд сролцоос татгалзсанд тооцож, энэ тухай дуудлага худалдааны тэмдэглэлд тусгана.

2.9 Оролцогч үнийн саналаа өгснөөс хойш 2 минутын дотор бусад оролцогч өмнө өгсөн оролцогчийн үнийн саналаас дээш үнийн санал өгөөгүй тохиолдолд тухайн улсын бүртгэлийн дугаар худалдагдсанд тооцож дуудлага худалдаа хаагдана.

2.10 Дуудлага худалдааны ялагч энэхүү удирдамжийн 3.8-д заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй болон дуудлага худалдааг хүчингүйд тооцсон тохиолдолд тухайн улсын бүртгэлийн дугаарыг дахин дуудлага худалдаанд оруулна.

2.11 Цахим дуудлага худалдааны эхлэх, дуусах цагийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын цагаар тооцно.

2.12 Цахим дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг цахим дуудлага худалдаа явагдахаас 3 хоногийн өмнөөс хүлээн авч эхлэн дуудлага худалдаа явагдах өдрийн өмнөх өдрийн 23 цаг 00 минутад зогсоож, бүртгэлийг хаана.

2.13 Дуудлага худалдааны үйл ажиллагааны зардалд дараах зүйлс хамаарна. Үүнд:

- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зар, мэдээ явуулсан зардал
- Программ хангамж хөгжүүлэлтийн зардал
- Дансны шимтгэл
- Сурталчилгааны зардал
- Бусад

Гурав. Дуудлага худалдаанд оролцох

3.1 Дуудлага худалдаанд оролцогч нь өөрийн оршин суух засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьялалтын дагуу улсын бүртгэлийн дугаарыг сонгон оролцно.

3.2 Дуудлага худалдаанд оролцохыг хүсэгч нь цахим системд бүртгүүлж, дэнчин төлснөөр оролцох эрх үүснэ.

3.3 Дуудлага худалдаанд Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, харьялалгүй хүн бүгд дуудлага худалдаанд оролцох эрхтэй.

3.4 Дуудлага худалдаанд оролцогч үнэ өсгөх доод хэмжээ нь 50,000 /тавин мянга/ төгрөг, дээд хэмжээ 1,000.000 /нэг сая/ төгрөг байна.

3.5 Дуудлага худалдааны зар мэдээлэлд заасан цаг хугацаанд оролцогч нь дуудлага худалдааны цахим системд нэвтэрсэн байна.

3.6 Цахим систем дуудлага худалдаа эхэлснийг мэдэгдэж хугацаа тоолж эхэлснээр дуудлага худалдаа албан ёсоор эхэлсэнд тооцно.

3.7 Тухайн дуудлага худалдаанд ялсан оролцогч зохион байгуулагчтай Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулна.

3.8 Дуудлага худалдаагаар худалдан авсан улсын бүртгэлийн дугаарын төлбөрийг тухайн дуудлага худалдаа зохион байгуулсаас хойш 24 цагийн дотор Хаан банкны 5039831355 тоот эсвэл Голомт банкны 1605186115 тоот дансанд төлж гэрээ байгуулна.

3.9 Худалдан авагч нь энэхүү гэрээг байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд бүртгүүлнэ.

Дөрөв. Дуудлага худалдааны дэнчин

4.1 Дуудлага худалдаагаар худалдах улсын бүртгэлийн дугаарын дэнчингийн хэмжээ нь 50000 /тавин мянга /төгрөг байна.

4.2 Тухайн дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын дэнчинг дуудлага худалдаа зохион байгуулсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор багтаан дэнчин төлсөн дансанд буцаан олгоно.

4.3 Дуудлага худалдаанд ялсан оролцогчийн худалдан авах улсын бүртгэлийн дугаарын үнийн төлбөрт дэнчинг оруулан тооцно.

4.4 Энэхүү удирдамжын 3.8-д заасан хугацаанд улсын бүртгэлийн дугаарын үнэ төлөгдөөгүй тохиолдолд тухайн улсын бүртгэлийн дугаарыг дахин дуудлага худалдаанд оруулах бөгөөд дэнчинг буцаан олгохгүй.

Тав. Дуудлага худалдааг дахин явуулах

5.1 Дараах тохиолдолд дуудлага худалдааг дахин явуулна:

5.1.1 Дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан улсын бүртгэлийн дугаарын үнийг энэ журмын 3.8-т заасан хугацаанд бүрэн төлөөгүй, төлөхийг зөвшөөрөөгүй эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд;

5.1.2 Дуудлага худалдаа явагдаагүй болон явуулах нөхцөл бүрдээгүй;

5.1.3 Дуудлага худалдаанд оролцогч бүртгүүлээгүй, нэг этгээд оролцсон, эсхүл

оролцогчдоос зөвхөн нэг нь үнийн санал өгч хүчингүй болсон дуудлага худалдаа;

5.1.4 Хууль зөрчин явуулсныг шүүхийн шийдвэрээр тогтоосон;

5.1.5 Хуульд заасан бусад тохиолдолд.

5.2 Дуудлага худалдааг дахин явуулах шийдвэрийг бүртгэлийн байгууллага буюу зохион байгуулагч гаргах бөгөөд дуудлага худалдааны зарыг дахин дуудлага худалдаа явуулах өдрөөс хуанлийн 7-оос доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

5.3 Дуудлага худалдааг дахин явуулахдаа энэ удирдамжийг мөрдөнө.

**Зургаа. Дуудлага худалдааны ялагчид худалдан авсан улсын
бүртгэлийн дугаарыг олгох**

6.1 Дуудлага худалдаанд ялсан оролцогчтой байгуулах гэрээнд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:

- 6.1.1. Худалдан авсан улсын бүртгэлийн дугаар;
- 6.1.2. Дуудлага худалдааны ялагч нь иргэн бол овог нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг;
- 6.1.3. Дуудлага худалдааны ялагч нь хуулийн этгээд бол байгууллагын нэр, регистер;
- 6.1.4. Үнэ төлсөн баримт;
- 6.1.5. Улсын бүртгэлийн дугаарыг захиалах хугацаа;

6.2 Дуудлага худалдааны ялагчтай байгуулсан гэрээг үндэслэн “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам”-д заасны дагуу тээврийн хэрэгслийн улсын дугаарыг олгож бүртгэл хөтлөнө.

Долоо. Бусад

7.1 Байгалийн давагдашгүй хүчин зүйл гарсан, эсхүл програм хангамж, техникийн саатал, цахилгаан эрчим хүч, сүлжээ тасарч доголдоноос цахим дуудлага худалдаа хэвийн явагдах боломжгүй болсон тохиолдолд тухайн дуудлага худалдааг хүчингүйд тооцож, дээрх нөхцөл байдал хэвийн болсоноос хойш ажлын 5 хоногийн дотор дахин зохион байгуулна.

---oOo---

“Автотээврийн үндэсний төв” ТОУТ
захирлын 2021 .. оны 08 сарын 10-дэдрийн
тоот тушаалтын хавсралт 2

А/70

**Улаанбаатар хотын сер бүхий үнэ хаялцуулан борлуулаж
улсын дугаарын жагсаалт /387/**

000A /9/ A000 /9/ AAAA /9/ 0AAA /9/	00A0 /9/, 00AA /9/, 00AB /72/		ABAB /90/		ABBA /90/		AABB /81/	
0001	0010	0045	0101	5050	0110	5005	1100	6600
0002	0020	0046	0202	5151	0220	5115	1122	6611
0003	0030	0047	0303	5252	0330	5225	1133	6622
0004	0040	0048	0404	5353	0440	5335	1144	6633
0005	0050	0049	0505	5454	0550	5445	1155	6644
0006	0060	0051	0606	5656	0660	5665	1166	6655
0007	0070	0052	0707	5757	0770	5775	1177	6677
0008	0080	0053	0808	5858	0880	5885	1188	6688
0009	0090	0054	0909	5959	0990	5995	1199	6699
1111	0011	0056	1010	6060	1001	6006	2200	7700
2222	0022	0057	1212	6161	1221	6116	2211	7711
3333	0033	0058	1313	6262	1331	6226	2233	7722
4444	0044	0059	1414	6363	1441	6336	2244	7733
5555	0055	0061	1515	6464	1551	6446	2255	7744
6666	0066	0062	1616	6565	1661	6556	2266	7755
7777	0077	0063	1717	6767	1771	6776	2277	7766
8888	0088	0064	1818	6868	1881	6886	2288	7788
9999	0099	0065	1919	6969	1991	6996	2299	7799
0111	0012	0067	2020	7070	2002	7007	3300	8800
0222	0013	0068	2121	7171	2112	7117	3311	8811
0333	0014	0069	2323	7272	2332	7227	3322	8822
0444	0015	0071	2424	7373	2442	7337	3344	8833
0555	0016	0072	2525	7474	2552	7447	3355	8844
0666	0017	0073	2626	7575	2662	7557	3366	8855
0777	0018	0074	2727	7676	2772	7667	3377	8866
0888	0019	0075	2828	7878	2882	7887	3388	8877
0999	0021	0076	2929	7979	2992	7997	3399	8899
1000	0023	0078	3030	8080	3003	8008	4400	9900
2000	0024	0079	3131	8181	3113	8118	4411	9911
3000	0025	0081	3232	8282	3223	8228	4422	9922
4000	0026	0082	3434	8383	3443	8338	4433	9933
5000	0027	0083	3535	8484	3553	8448	4455	9944
6000	0028	0084	3636	8585	3663	8558	4466	9955
7000	0029	0085	3737	8686	3773	8668	4477	9966
8000	0031	0086	3838	8787	3883	8778	4488	9977
9000	0032	0087	3939	8989	3993	8998	4499	9988

0034	0089	4040	9090	4004	9009	5500	
0035	0091	4141	9191	4114	9119	5511	
0036	0092	4242	9292	4224	9229	5522	
0037	0093	4343	9393	4334	9339	5533	
0038	0094	4545	9494	4554	9449	5544	
0039	0095	4646	9595	4664	9559	5566	
0041	0096	4747	9696	4774	9669	5577	
0042	0097	4848	9797	4884	9779	5588	
0043	0098	4949	9898	4994	9889	5599	

**Орон нутгийн сер бүхий үнэ хаялцуулан борлуулах
улсын дугаарын жагсаалт /18/**

000A /9/	0001	0002	0003	0004	0005	0006	0007	0008	0009
AAAAA /9/	1111	2222	3333	4444	5555	6666	7777	8888	9999

---oOo---